https://doi.org/10.69561/mjac.v25i49.3829 **Article | Fasc.4**

Монгол соёл иргэншил дэх үхэр тэрэг, түүний хийц, хэрэглээ, үг хэллэг

Мижиддоржийн Энхбаатар
Соёл урлагийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, ахисан түвшний хөтөлбөрийн алба, Улаанбаатар, Монгол Улс
✉ mijidenkhbaatar@gmail.com

Хураангуй: Өнөөгийн монголчуудын дунд үхэр тэрэг хийж, амбан шараа сурган хөлөж, отор нүүдлийн ая дагаж буй газар тун цөөхөн билээ. Тиймээс нийт монголчуудын хувьд үхэр тэрэг хийх уламжлал, хэрэглээ, түүнтэй холбоотой хэл хэллэгүүд аажим аажмаар алсарч байна. Тус өгүүлэлд Хангай нурууны ар, өврөөр нутаглан, ахуй амьдралдаа үхэр тэргээ ашигласаар буй Хөвсгөл, Завхан, Архангай аймгийнхны дунд хийсэн угсаатны зүйн судалгаанд тулгуурлан үхэр тэрэг хийх уламжлал, үхэр тэрэгний төрлүүд, тэрэгчдийн ур ухаан зэргийг хуваалцах юм.

Түлхүүр үгс: *соёлын биет бус өв, үхэр тэрэг, бүтэц, хэрэглээ, үг хэллэг*

Oxcarts in Mongolian civilization, its construction, usage and phrases

Enkhbaatar Mijiddorj
Research and Advenced studies, program department, Mongolian National University of Arts and Culture Ulaanbaatar, Mongolia
✉ mijidenkhbaatar@gmail.com

Abstract: Among Mongolians today, there are very few people who make oxcarts, train their oxes, and move around. Therefore, for all Mongolians, the traditions and usages of making oxcarts, as well as related phrases, are slowly disappearing. In this article, based on the ethnographic research conducted among the Khuvsgul, Zavkhan, and Arkhangai provinces, who live on the back and sides of the Khangai mountain range and still use oxcarts in their daily lives, we will share the tradition of making oxcarts, the types of oxcarts, and the skills of the oxcarters.

Keywords: *intangible cultural heritage, oxcarts, construction, usage and phrases*

Оршил

Монгол үндэстний соёлын биет бус өвийн томоохон илэрхийллийн нэг бол уламжлалт “Нүүдэллэхүй ёсон” билээ. Ардын мэдлэг ухаан, байгаль хамгаалах уламжлалт мэдлэгт тулгуурласан нүүдэллэхүй ёсыг бүрэлдүүлж буй биет ба биет бус соёлын өвийн дотор эртнээс нааш монголчуудын аж амьдралд нүүдэл, отор,

Received: 2024.08.31/ Accepted: 2024.11.27
© Author (s). 2024

худалдаа наймаа, аж ахуйн бусад зүйлсэд өргөн хэрэглэж ирсэн нэгэн зүйл бол "Үхэр тэрэг" юм.

Энэхүү уламжлалт соёлын өв, түүнийг хийх, хэрэглэх, бэлгэдэхтэй холбоотой эрдэм ухаан нь орчин цагт цөөн газар уламжлагдан үлджээ. Бүс нутгийн хувьд авч үзвэл, Хангайн нурууны хойд хэсэгт голлох бөгөөд энэ хэсэгт залган орших Солонгот, Хожуул, Тарнат, Загастайн даваануудаар зорчин нааш цааш оторлож явдаг Завхан, Архангай аймгийнхны дунд тэрэг хийх уламжлал хадгалагдаж байна. Засаг захиргааны нэгжээр хэлбэл, үхэр тэрэг хийх уламжлалт соёл Сайн ноён хан аймгийн Далайчойнхор вангийн хошууныхан буюу одоогийн Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр, Галт, Жаргалант, Архангай аймгийн Хангай, Цахир, Тариат, Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл сумын орчимд ихээхэн хөгжиж, алдартай тэрэгчид олноор амьдарч байв. Энэ нутгийнхныг бусад газрынхан "***Баасан дугуйтай, дээсэн тоногтой Далай вангийн хошууныхан***" гэдэг байсан нь тэрэгний дугуй, шаантгийг үхрийн нойтон баасаар шавдаг байсантай холбоотой. Харин сарлагийн дээсэн хударга хэрэглэдэг учраас "дээсэн тоногтой" гэдэг аж. Тиймээс бид эл өгүүлэлдээ энэ нутгийнхны тэрэг хийх уламжлал, хэрэглээ, үг хэллэг зэргийг авч үзэх болно.[1]

Судалгааны арга зүй

Оролцон ажиглалт, ярилцлага, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх

Судалгааны үр дүн

Нүүдэлчид таван хошуу малаасаа бод мал бүрд тохирсон тэрэгний зүйл зохиосон нь олон мянган жилийн түүхтэй соёлын өв болж, археологийн дурсгал тэргүүтнээс олонтоо илэрсэн нь бий. Харин нэлээн сүүл үе буюу XX зууны эхэн үеийн аялагч, судлаачдын тэмдэглэлд ч монголчуудын энэхүү уламжлалт хөсгийн талаар сонирхон тэмдэглэсэн зүйлс байдаг. Тухайлбал, жин тээж байсан тэмээн хөсөг болон үхэр тэрэгний хонхны дууны тухай Данийн аялагч Хеннинг-Хаслундын тэмдэглэлд үлдсэн нь,

> *"Жинчид мал амьтан хуухайлчихаагүй идэш сайтай уст цэгийн орчим буудаллаж, шөнийн хэдхэн цагт л амарч, гялалзан анивалзах оддын доор гагцхүү Монголд л ийм байдаг. Хоногложж, говийн шөнийн этгээд сонин дуу чимээг таашаалалтайяа сонсон хэвтнэм. Алсаас тэмээний жүн хонхны жингэнэх дуун сонсогдном. Энэ бол ачаатай тэмээнийх биш, шөнийн бэлчээртээ идээшлэн яваа тэмээний хонхны дуун. Тэд бээр жингийн зам даган айсуй бус, алсад элсэн дов довцогийн хооронд чимээ аниргүй хэрэн бэлчиж яваа. Гагцхүү хонхны хонгинох дуу л тэднийг хаана байгаа, хаашаа явж буйг илчлэх ажгуу. Би бас үхэр тэрэгний хөсгийн хурдан цохилох хонхны дууг сонсном. Эхлээд ганцхан хонхны дуу жингэнэн аажмаар шөнөжингөө үргэлжлэн дуугармуй. Тэгснээ бүр алсаас жингэнэх хонхны дуу намуухнаар дагалдах хөгжим лугаа хоршин дуугарна. Энэ бол шөнийн тэнгэрт гялалзах од мичдийн дор уянгалан эгшиглэхүй говь цөлийн найралт хөгжим болой"* (Хеннинг 2015, 84) хэмээн

[1] Энэхүү өгүүллийг БШУЯ, Шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлж буй ШУТБИХХЗГ-2022/209 тоот төслийн хүрээнд бичив.

их говийг туулан яваа жинчдийн хөсөг, жингийн хонхны дууг яруу сайхнаар дүрсэлжээ.

Монголчуудын аж ахуй эрхлэлтдээ ашиглаж ирсэн үхэр тэрэг нь дараах хэд хэдэн төрөл байна хэмээн бид үзэж байна. Үүнд:

- Суман тэрэг
- Чагтан тэрэг
- Нуухан тэрэг
- Хаймар дугуйтай тэрэг зэрэг байх бөгөөд эдгээрийн гол ялгаа нь дугуйндаа байна.

Үхэр тэрэгний эдгээр төрлөөс малд хамгийн тохиромжтой нь **суман тэрэг** байдаг. Учир нь суман тэрэг хөнгөн, цасанд явахад сайн.

Чагтан тэрэг хийхэд амархан ч цасанд явахад нүхэнд нь цас хахчихаад явдаггүй, ганга жалганд бүр муухан гэж малчид хэлдэг. Гэхдээ шар үхэр цасанд сууна гэж бараг үгүй. Тэрэгний голд их цас тулж, явуулахгүй болохыг "***ганжиндах***" гэх бөгөөд энэ үед ч шар үхэр тэргийн голыг чирсээр гардаг гэдэг.

Нуухан тэрэг нь дугуйны хүрээ төмөр учраас жижиг чулуу дамнан гарсан ч тээглэн донсолж буулга доргиодог, чулуугүй газар бол элсэнд шигдэн улам ачаа хүндрүүлдэг тул дугуйны бат бөхийг бодож сургаж буй бага үхэрт голдуухан хэрэглэнэ.

Зураг 1. *Шаантгийг нь үхрийн баасаар шавсан тэрэг. Үндэсний төв архив*

Сүүлийн жилүүдэд хэрэглэж байгаа **хаймар дугуйтай тэрэг** нь модон дугуйтай тэргийг бодвол арлыг нь арай уртавтар хавтгай модоор хийж байгаа тул хэмжээнийхээ хэрээр тавьсаар ачаа заавал хүнддэх гэдэг байдаг. Энэ тэрэг нь хийтэй дугуйтай тул өнхрөх хурд сайн ч, уруу газар хурдаа авч, шар түрэх, өгсүүр өөд улам хойш зүүгдэн чангаах, өвс зэрэг овор ихтэй ачаатай үед дов сондуул таарвал хийдэн онхолдох талтай байдаг. Хаймар дугуйтай тэргэнд намхан болоод өргөн дугуй байвал сайн.

Өвлийн отрын үедээ үхэр тэргийг байнга хэрэглэж заншсан Завхан аймгийн Их-Уул сумын малчин Б.Мөнхбат ярихдаа:

"Тэргийг намар аажуухан юм уу, хавар эрт хийнэ. Намартаа бол мод шарласан хойно, хавар бол мод ногоорохоос өмнө хийдэг. Модоо аваад сайхан зүсэж цоолчихоод хонины шар өтгөнд булна. Салхи үзүүлэхгүй хатаах ёстой. Хонины шар өтгөнд хийж, ан гарахгүй, хагсахгүй болгож хатааж байгаа юм, тэрэг нь бөх, сайн болдог. Дээр үеийн улсын модоо авч янзлах үндсэн арга нь энэ. Модон тэрэг отрын нутагт очоод хоёр гурван сар хөдлөхгүй байхаар хагсана. Чанар муутай модоор засаж сэлбэх ч хэцүү, тэгэхээр үхрийнхээ баасаар шавж хөлдөөгөөд л аргална. Одоо модон дугуйг солиод хаймар дугуйтай

болоод байгаа. Зарт[2] *талдаа ганц нэг модон дугуйтай тэрэг явж байна. Тэнд чанартай, өндөр тэгшхэн мод ургадаг. Харин Цахир талын мод богинохон, яр ихтэй болохоор юм хийхэд хэцүү. Намхан мод гэдэг цуулбар муутай яр ихтэй бах байдаг юм. Бөгс нь айхтар бүдүүн, орой өөдөө шулдан (шувтан) алсуураа мод багатай л даа. Манай нутаг Их-Уулд тэрэг хийдэггүй хүн гэж бараг байхгүй. Хийдэггүй юм аа гэхэд засаж сэлбэдэггүй хүн гэж байхгүй. Дээр үед ерөөс хаймар байхгүй байхад дугуйгаа дөрвөлжиндүү маягтай хийчихдэг байлаа, тэгэхлээр өөд газар ухарч алдахгүй, уруу газар бас айхтар түрээд байдаггүй талтай байдаг юм. Малдаа бол хамгийн л эвтэйхэн нь"* (Нялцгайтан овогт Б.Мөнхбат 2018, 2019) хэмээж байлаа.

Харин тэрэг хийх арга ажиллагаа, ямар мод сонгох тухай нарийвчлан авч үзвэл дараахаар ойлгож болно.

"Хар модоор тэрэг хийнэ. Модыг хавар, эсвэл өвөл авна. Яргүй, баадуу байхгүй мод авна. ***Баадуу*** *гэж цагаригтай модыг хэлдэг. Тийм модыг хөрөөдөж сэврээнэ. Баадуутай мод бол сэврээхэд эргүүлэг нь гарна, тийм модоор тэрэг хийдэггүй. Эргүүлгээрээ өмхөрчихдөг. Ер нь багцаагаар наймын хувингаас жаахан бүдүүхэн мод орно. Хоёр мод унагахад хоёр, гурван тэрэг гарна. Тархины мод нарийхан мод байна. Бүдүүхэн модоор хийнэ гэвэл хоёр модноос дөрвөн дугуй гарна. Хоёр мод унагаах учир бол нэг модоор хийвэл дугуй нь далий элэгдэнэ. Хоёр бөгсөөр нэг тэрэг, хоёр цээжээр нэг тэрэг хийнэ. Бөгс мод хатуу, цээж рүүгээ бол зөөлөрнө. Тархи хийвэл тархиныхаа хоёр талд яр оруулбал сайн. Мөөрний мод бол бөгс мод байна. Түүний залгаанаас тархиныхаа модыг авна. Мөөрөө суулгах дугуйны голыг тархи гэнэ. Хоёр талд яртай мод хийвэл хагарахгүй. Сумаа зангидна. Тархиа цоолоод сумаа хийнэ. Хоёр талаа самнана. Мөөрөө зүсэж цоолоод амгай хийнэ, амгайлна. Дундуур нь 5 пунгийн цүүц гэж бий. Хумсны толионы хэртэй. Тэрүүгээр хоёр талаас нь ухаж хонхойлгоод мөөрийг суулгана. Нэг мөөрийг 4 ухна. Тэгээд тархи, амгайг тэр цүүцээрээ цүүцдээд, сумны цүүц бол эрхий хуруу босоогоороо байгаа юм шиг цүүцээр тархи, сум, мөөрийг цоолно. Тэр их авир гүйцэтгэнэ. Сүхээр шоодно, үлгэрээр могойвчлоод, үлгэрлээд, тархи, нүх, амгай руугаа сумны амгайг оруулаад шаана. 4 мөөр, 2 тархи, 2 сум мөр нийлээд нэг дугуй болно.*

Арал (гуя), гол бол тусдаа. Халуун савнаас бүдүүхэн хэрийн модоор хийнэ. Найман данз орно. Сумны цүүцээр цоолно, тусдаа нарийн мод байна. Бүдүүн модоор цуулахгүй. Хоёр бөгсийг голоор нь зүсээд 8 мөөр, 2 тархи гарна. Цээж, бөгс холивол өөр учраас элэгдэнэ. 2 хатуу, 2 зөөлөн орно гэсэн үг. Тэгш шулуун, яр бага, мөчир бага хатуу мод байна. Нойтон модоор хийнэ. Тоншуул цохисон шүүдэнгэ мод чиг л болно. Бөгсийг нь "Шүүдэнгэ" гэдэг юм. Би нойтон мод унагадаггүй. Түлээний үзүүр хуурай, бөгс нь чийгтэй модоор хийнэ. Ширэнгэн мод тэргэнд их сайн, улаан бахан мод сайн. Ширэнгэн мод цагаандуу болохоос бөх, тэгэхдээ улаан бахандуугаа гүйцэхгүй. Газар газрын мод өөр учраас хатуу модтой газар байдаг. Би модоо хоршооллоос авч байсан. Дээр үед лусаа хамгаалаад, догшин гээд авдаггүй байсан. Тийм газраас авбал ханиад түрдэг,

[2] Их-Уул сумын нэг баг

сэтгэл дагадаг тэгээд хүрээд ирдэг учиртай.

Өндөр-Улаанд Бургасны эх рүү Шугуйт зураа гэж газар бий. Тэнд яргай байдаг, тэрийг ёстой авахуулдаггүй гэдэг. Манай адаг руу Жонштын хөвөө гэж бий, бас тэндээс авахгүй. Тэндээс манай аав мод авсан юм гэнэ лээ. Тэгсэн гэрийнх нь хоёр дээврийг тэр дор нь салхи хуу татаад хаясан гэдэг юм.

Нэг хийсэн тэрэг бол модоороо болно (чанар нь модноосоо шалтгаална). Улаан бахаар хийсэн тэрэг их нүүдэг айлд 4-5 жил болно, зөөлөн модоор хийсэн тэрэг 2-3 жил болно. Бөгс хатуу мод, цээж хатуу мод гэж байна. Зөөлөн модоор хийвэл балбайгаад сөрдийнө. Гол нь мөр юм шүү дээ. Буулганы доогуур уях сурыг боодуу гэнэ. Буулган сур. Гүүшин [түүшин], данз. Түүний гол руу дугуй хийж, хоёр модоор шаана. Тэрийг "тайшуу", "тайшигнах" гэнэ. Хоёр дугуйнд 4 орно. Бүгдийг нь хар модоор хийнэ. Чагт буюу дугуй руу холбосон хэсгийг чих гэнэ. Хөндлөн хийдгийг нь "чагт" гэнэ (Ичинхоролын Нинжбадгар 2017).

Одоо ч Хангайн нуруу орчимд сайн муу, сайхан муухай гэхээс бус айл бүрд л тэрэг хийдэг хүн байх ажээ. Муухан тэрэг, тэрэгчнийг янз бүрээр л нэрлэнэ. Тухайлбал, "*Онход*[3] *тэрэг хийдэггүй хүн гэж байхгүй, одоо ч гэсэн бүгдээрээ муруй сарий юм хийнэ. Хойд Тэрхийнхэн Онход ирж тэрэг хийж сурч байсан. Бүр тэрэгний сургууль шахуу байсан гэдэг. Хойд Тэрх, Цахирынхан анх тэрэг хийж мэддэггүй байлаа л даа. Миний ах Санжийг гэхэд "**гуя муутай тэрэгчин**" гэдэг байсан, тэгэхдээ сарайлгаад л хийдэг байв*" (Бор Адуун овогт Балданхүүгийн Шижээ 2017);

Зураг 2. *Шар хөлөсөн тэрэг. 1974 он, Үндэсний төв архив*

"*Манай аав тэрэг хийдэг хүн байсан, задгай сумтай тэрэг гэж хоёр талаас нь шаадаг байна. Битүү шаантгийг "**бинтүү**" гэнэ. Дугуйнд 4 мөөр орно. Сүүл үед "**Залхуу тэрэг**" гэж нэмэх тэмдэг шиг хөрөөдөөд чагталж байна, мөөрөө цоолохгүй шууд ам гаргаад мөөр сум хоёроо хадчихдаг. Тэрэгний модонд улаан*

[3] Онх. Цахирын нутаг

мод сайн. Бухан мод гэж зах нь шулуун судалтай улаан мод байдаг. Цагаан модоор хийвэл элэгдэл ихтэй болно” (Самбуугийн Баасансүрэн 2017) гэхчлэн ярих ой дурсамж, туршлагыг монгол соёлын эд эс хэмээн хүлээн зөвшөөрч, суралцах, уламжлуулах үүрэгтэй билээ. Тэрэг хийх уламжлал, арга ажиллагааг дахин нэг тэрэгчний яриагаар үргэлжлүүлбэл, “Суман тэрэг нь дугуйны дөрвөн мөр, сум, тархи, гол, шаантгийг паашаан (тайшаан), чих, арал, гүүшин, гуя, арал, соёо зэргээс бүтдэг. Чагтан тэрэг нь суман тэрэгнээсээ бага мод ордог. Гэхдээ суман тэрэг эдэлгээ сайн. “**Хайнагийн шар, хар модон тэрэг хоёр эдлэхгүй болохоор мууддаг”** гэсэн үгтэй.

Тэрэгний мод сонгохдоо хамгийн чухал нь гол нь эргээгүй, цаашдаа эргэхгүй мод авна. Доошоо мөчир багатай, нимгэн цагаан хөхдүү арьстай, улаан биш. Яр байлаа ч нарийн байвал гайгүй. Бүдүүн яртай бол эдэлгээндээ яр нь унаад түүнийгээ дагаж хугарах гээд байдаг. Нүх сүв гаргах болсон ч том яртай мод санаан зоргоор цоолж болдоггүй, яраа дагаад нүх томорчих ч талтай. Тархины модыг бол хэмжээд тайраад авчихна.

Мөрийг [мөөр М.Э] “***тэмээчилнэ***” гэж хоёр махийсан юм гаргаж ирнэ. Дараа нь модныхоо овонтой талаас цавчаад байхаар аандаа мөр нь доошоо хараад, дээшээ харах хоёр нь тахир болоод ирнэ. Доод талыг дугуйлж авахыг л “тэмээчлэх” гээд байгаа юм. Матигар дугуйгаа тааруулж цавчсан хойноо нүх хаана гаргахаа үлгэрээрээ зураад гаргачихдаг. Гадна тал зузаан, дотор тал нимгэн байна.

Өвлийн цагт модон тэрэгнийхээ дугуйг үхрийн баасаар битүү баастана. Тэгээд 1-2 хонуулахад бариад хөлдөнө, баастай тэрэг хагарна гэсэн үг байхгүй. Харин хавар зуны үед хийсэн тэрэг хагарна. Тиймээс намар мод хөлдөнгүүт хийдэг юм.

Тэрэг хийхэд ооль, шоо орно. Шоодох гоёулахын тулд зурах харандаа, цүүц, сүх орно. Ооль бол мөрний дотрыг матахад чухал эд. Ерөөсөө ооль, гадна талд бол шоо орно. Шоо бол зогсож байгаад гуя, данзаа цавчдаг ойлорхуу, урт иштэй, тахир, өргөн иртэй эд байна. Тэргээ угсарч бэлэн болгоод оолиор засаж гоёж өгнө. Одоо тэргийг хаймарладаг болжээ, суман тэргийг хаймарлаад хэрэггүй (Дүгэрийн Дамдин 2017).

Энэ мэтээр тэрэгчдийн ярианууудаас харвал, тэрэгний модыг хагарахгүй болгож хагсаах хэд хэдэн арга байна. Шар өтгөнд булах, буцалгах, мөн “намраас дараа намар хүртэл модондоо модоо хаяад жил илүү болгоно. Дугуйгаа цавчаад модон дотор хаяна” зэрэг аргууд байна. Эндээс харахад эмээлийн мод хатаах болон тэрэгний мод хатаах арга ажиллагаа нь монголчуудын дунд бараг адилаар уламжлагдаж иржээ.

Үхэр тэргийг бүрдүүлэх хэсгүүдийн тухайд өмнө хэрхэн хийдгийг өгүүлсэнчлэн газар газар өөрөөр нэрлэнэ. Ерөнхийд нь бүдүүвчилж харвал, тэрэгний дугуй хэсэгт л олон зүйлийн бүрдэл, тэдгээрийг нэрлэсэн нэршил олонтой. Тиймээс л модны дархны ур ухааныг дугуй, шаантаг л харуулна.

Зураг 3. *Үхэр тэрэгний мөөрийг өөлөн хэлбэржүүлж байгаа нь. Үндэсний төв архив*

Тэрэгний арал буюу гуя

Тэрэг чарганы мал хөллөх зэрэгцээ хоёр урт иш буюу гуя, түүний хойд хэсгийг хөндлөөр холбох бөгөөд тэнхлэгт суулгана. Арлыг хийхдээ урт хоёр гуя модны хойд хэсэгт хэм тэгш хоног, нүх гарган, ялуу хэмээх 8-10 хөндлөвч модоор холбон ачаа ачих боломжтой болгодог.

Тэрэгний бул

Тэрэгний голыг тойрон эргэх, мод төмрөөр хийсэн хөндий булцуу, дугуйн төвийн бүдүүн хэсэг.

"Булаар жанчихад инээж, булгаар зүлгэхэд уйлах" гэсэн зүйр үг байдаг нь ааш нь олдохгүй байх гэсэн санааг илэрхийлдэг.

Тэрэгний дугуй

Тэрэгний өнхрөн явах хүрд

Тэрэгний мөөр

Модон тэрэгний дугуй хүрээ

Тэрэгний шаантаг

Үхэр тэрэгний хамгийн чухал зүйл нь шаантаг гэдгийг тэрэгчид хэлдэг. Шаантгаа ихэд арчилж, холхиулж муутгахгүйгээс л үхрийн баасаар шавдаг байна. Шаантгийг сайн шаасан тэрэг 4-5 жил болдог гэдэг. Харин тэрэгний шаантгийг анх хийхдээ хэрхэн уран, нарийн аргаар хийх тухай сонирхвол,

"*Паашаа буюу шаантгийг сайн шаах ёстой, шаантаг сайн шаах нүхнийх, дээр үед бол үзүүр нь хуруу гардаг ёстой гэдэг. Хуруу гарснаас цааш бол шаантагны үзүүр эргэнэ, эргэж байгаа хэсэг нь их нимгэхэн байна гэсэн үг. Шаантагны үзүүр тэгж эргэхийг "**нохой сүүллэх**" гэдэг. Нохой сүүллүүлээд шаасан модтой тэрэг хэзээ ч сугарахгүй. Шаантаг шаагаад хуруу хэртэй гараад, доорх нь эргээд, цагариг болоод дээд талдаа ирээд наалдчихна гэсэн үг. Харин шаантагны үзүүр нимгэн биш домбогор үзүүр гаргаад шаавал хагсахаараа сугараад уначихдаг.*

"Нохой сүүллэх"-д махир шаантаг шаахгүй, мөрөндөө шаагаад хуруу гартал шаахад өөрөө эргээд нохой сүүл болно. Үзүүр нь тийм нимгэхэн орохоор хэмжээтэй нүхээ зурж цоолдог байна. Дээд тал хуруу гаран зузаан, доод талын үзүүр ойлоор цавчаад хутганы ир шиг болгоно доо.

Шаантгаа халуун усанд буцалгаад давирхай нь гоожоод ирэхээр халуун чигт нь шаантаглана. Буцламхай давирхайндаа зууралдаад эргээд гарахгүй болно. Зүгээр нойтон мод эргээд гарчихдаг. Тэрэг хийхэд шаантаг л бүх юмаа барина, нүхний хэмжээ ямар ч зөрүүгүй байна. Нүхний хэмжээ зөрүүтэй бол сумаа хугалдаг" (Дүгэрийн Дамдин 2017) аж.

Зураг 4. *Тэргэнд шар хөлөөж байгаа нь. Завхан аймаг, Отгон сум, 2019 он.*

Хэлэлцүүлэг

Үхэр тэрэг, түүнийг дагалдан бүрэлдсэн олон өвийн дотор нэг талаар соёлын биет бус өвийн "*Эх хэл, аман уламжлал*"-ыг илтгэх илэрхийлэл болсон, нөгөө талаас угсаа-хэл шинжлэлийн судлагдахуун болсон олон арван үг хэллэг буйг ангилан үзвэл,

1. Үхэр тэрэгний бүтвэр хэсгүүдтэй холбоотой: *шаантаг, паашаа, түүшин, тайшуу, бинтүү, гуя, тархи, соёо, чих, мөөр*, *гилгүү*;
2. Үхэр тэрэгний мод сонгох, хийхтэй холбоотой: *бах (бух), баадуу, шүүдэнгэ, амгайлах, могойвчлох, тэмээчлэх, нохой сүүллэх*;
3. Үхэр тэрэг болон тэрэгчинтэй холбоотой: *залхуу тэрэг, гуя муутай тэрэгчин* гэх мэт үгс бий.

Эдгээр үгсийн нэгдүгээр хэсгийг ажиглан харвал, үхэр тэрэгний бүтвэр хэсгүүдийг нэрлэж байгаа нэрлэлтүүд нь ихэнхдээ хүн, амьтны бие эрхтний нэрлэлтүүдтэй адилхан байгааг харж болно. Өөрөөр хэлбэл, *чих, соёо, тархи, гуя, түүшин* зэрэг нь хүн, амьтны бие эрхтний нэршил бөгөөд үүгээрээ нүүдэлчид өөрсдийн зохион бүтээж, хэрэглэж байгаа эдийн соёлын зүйлийн бүрэлдүүлбэрүүдийг нэрлэж байгаа нь "хэлний метафор"-ын нэг болох "амьдчилах" сэтгэлгээ болно. "Нэг юмын шинж, үйлдлээр нөгөө юмын шинж байдлыг танин мэдэх буюу шинжлэх ухаантай байна гэдэг нь хүн төрөлхтний оюун билгийн нэг гайхамшиг" (Баянсан 2016, 214)-ийн замаар нүүдэлчид тэрэгний гол модыг тархи, хоёр урт арлыг гуя, дугуйн мөр гаргах хэсгийг мөөр[4] гэх мэтээр нэрлэсэн нь харагдаж байна.

[4] мөөр: мөр = энэ нь хүн, амьтны хөлийн мөртэй адилтгаж байна.

Харин хоёрдугаар хэсэгт буй тэрэг хийх үеийн арга ажиллагааг заасан үгсээс ихээхэн сонин содон зүйлийг ажиглаж болохоор байна. *Амгайлах, тэмээчлэх, нохой сүүллэх* гэх мэт үгсээс бид хүн төрөлхтний мал, амьтны төрөл зүйлсийг гэршүүлж, гаршуулах үеийн үзэл сэтгэлгээг харж болно. Нэгдүгээр бүлгийн үгстэй адилаар тэрэг хийж, урлан бүтээхдээ тухайн хийж буй тэргээ "амьдчилан" үзэж, ингэхдээ мал, амьтныг гаршуулж буй мэтээр арга ажиллагаагаа нэрлэж байгаа юм. Тухайлбал, "амгайвчлах гэдэг нь тэргийн дугуйг бүтээхдээ мөөр хэсгүүдийг углуургадаж оруулах"[5]-ыг хэлж байх бөгөөд адуу малыг авгайвчлах, түүнээс цаашлаад адууг гаршуулсан архетип уг нэрлэлтэд хадгалагдаж буйг илэрхийлнэ. Учир нь адууг гаршуулсан хамгийн чухал тоног хэрэгсэл бол амгай бөгөөд зэрлэг адгуусыг толгойноос нь эхэлж номхруулсан түүхтэй (Энхбаатар 2020, 6).

Гуравдугаар хэсэгт байгаа үгс мөн л үхэр тэргээ хүншүүлэн нэрлэсэн нэрлэлтүүд байна. Гуя муутай тэрэг хэмээх нь хийц муутай ч хэрэгцээг хангасан тэргийг хэлж байгаа бол, тэрэгний мөөрийг хялбар аргаар хийснийг "залхуу тэрэг" хэмээн нэрлэж байгаа нь залхуу хүнтэй адилтгасан метафор нэрлэлт болжээ.

Ийнхүү харахад, нүүдэлчдийн соёлын биет болон биет бус өвүүдийн нэрлэлтүүдээс бид аж ахуйн эртний хэлбэр, ирэл гаралтай холбоотой зүйлсийг нөхөн олж харах боломжтой байна. Тиймээс ч "Орчин үед дэлхий дахинаа төрийн хэлний бодлого нь тэлж түгэхээс гадна даяаршин дангааршиx мэдлэг тээсэн хэл буюу соёлын өргөн багтаамжтай төрөлх хэл, эх хэл, үндэсний хэл, шинжлэх ухаан, соёл боловсролын хэлтэй байхыг эрхэмлэн тэмүүлж байна" (Пүрэвсүрэн 2021, 105).

Зураг 5. *Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сум, 2015 он.*

[5] Адууг амгайвчлах нь адууны аманд амгайг углуургадан оруулахтай адил сэтгэгдэж байна.

Дүгнэлт

Монголчуудын үхэр тэрэг хийх уламжлалт арга ажиллагаа, бүрдэл хэсгүүд, тэдгээртэй холбоотой үгсийн санг нарийвчлан үзээд дараах хоёр зүйлийг хэлмээр байна.

Нэгд, Монголчуудын түүхэндээ хэрэглэж ирсэн олон зүйлийн тэрэг болох гэр тэрэг, сүйх тэрэг, дөрвөдийн дөрөвдэй тэрэг, баргын мухлиа тэрэг, хам тэрэг, хүлиэр тэрэг, шар булуут тэрэг, хамниганы однохол тэрэг, пар тэрэг, буриадын ходоог тэрэг, МНТ-д гардаг өлжигтэй тэрэг, цаашлаад цоохор тэрэг, шанш тэрэг, чингэлэгт тэрэг гэх мэтээс эдүгээд уламжлагдаж, өнөөгийн Монголд хэрэглэж буй нь үхэр тэрэг, тэмээн тэрэг, морин тэрэг дангаараа байна. Гэвч эдгээр нь орон даяар бус, тодорхой бүс нутгуудад л хадгалагдан үлдсэн ба үхэр тэрэг нь Хангайн нурууны ар, өврөөр голлон уламжилсан биет ба биет бус соёлын өвийн цогцолбор эд зүйл юм.

Хоёрт, Үхэр тэрэг хийх арга ажиллагаа, бүтвэр хэсгүүд, тэдгээрийн нэршлийг зөвхөн толь бичигт тусгагдсанаар хязгаарлах бус, өнөө ч ард түмний дунд хэлэгдэж байгаа үг хэллэгүүдийг цуглуулан, соёлын ямар архетип, хэлний ямар метафор тэдгээрт хадгалагдан үлдсэнийг тодруулах боломжтой байна. Энэ жишгээр зөвхөн үхэр тэрэг гэлтгүй ахуй соёлын бусад нэрлэлтүүдээс ч тодруулах шаардлага бүхий чухал үе иржээ.

Ашигласан материалын жагсаалт

Баянсан, Ж. 2015. *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.

Пүрэвсүрэн, Б. 2021. *Хэл, соёлын онтологи*. Улаанбаатар: Хөх Монгол принтинг.

Хаслунд-Кристенсен Хеннинг. 2015. *"Явна аа," Travel Classic Books, 1-р боть*. Орч. Баярсайхан Б. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Энхбаатар, М. 2020. *Малын тоног хэрэгсэл: Аж ахуйн хэрэглээний толь*. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн:

Энхбаатар, М. 2016. *Архангай аймгийн Эрдэнэбулган, Цахир сумдад ажилласан угсаатны зүйн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн.* ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Баримт мэдээллийн төв. 2024.08.10.

Энхбаатар, М. 2019. *Завхан аймгийн Их-Уул сумд ажилласан угсаатны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн.* ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Баримт мэдээллийн төв. 2024.08.10.

Ярилцлага:

Бор Адуун овогт Балданхүүгийн Шижээ (Архангай аймгийн Цахир сумын малчин)-тэй хийсэн ярилцлага. Архангай аймаг: Цахир сумын нутагт, 2017 он.

Ичинхоролын Нинжбадгар (Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Тээл багийн малчин)-тай хийсэн ярилцлага. Архангай аймаг: Өндөр-Улаан сумын Тээл багт, 2017 он.

Нялцгайтан овогт Б.Мөнхбат (Завхан аймгийн Их-Уул сумын малчин)-тай хийсэн ярилцлага. Завхан аймаг: Их-Уул суманд, 2018, 2019 он.

Самбуугийн Баасансүрэн (Архангай аймгийн Эрдэнэбулган сумын малчин)-тэй хийсэн ярилцлага. Архангай аймаг: Эрдэнэбулган сумын нутагт, 2017 он.

Цагаан овогтой Дүгэрийн Дамдин (Архангай аймгийн Цахир сумын өндөр настан)-тай хийсэн ярилцлага. Архангай аймаг: Цахир сумын нутагт, 2017 он.